



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар ХЭГ/2359

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилт, бэлчээр ашиглалтын талаар мэдээлэл хийх болсныг үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



 Г.ЗАНДАНШАТАР

**МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ
БАЙГАА БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ТАЛААР
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Улсын Их Хурлаас батлан хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-үүдэд мал аж ахуйн салбарын хөгжлийн дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудыг тодорхойлсон билээ.

Мөн Засгийн газар 2018 оны 2 дугаар сард “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг баталж, хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Нэг. Мал аж ахуйн салбарын зарим үндсэн үзүүлэлтүүд

Мал аж ахуйн салбар нь ДНБ үйлдвэрлэлийн 10.6 хувь, экспортын орлогын 8.4 хувийг бүрдүүлж байгаа ба тус салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл жилээс жилд өсч, 2017 онд 3.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 5.9 хувиар нэмэгдсэн байна.

2017 оны гүйцэтгэлээр тус салбараас 426.1 мянган тонн мах, 30.6 мянган тонн хонины ноос, 1.9 мянган тонн тэмээний ноос, 10.2 мянган тонн ноолуур, 14.5 сая ширхэг арьс, шир, 96.7 сая ширхэг өндөг, 177.4 тонн зөгийн балыг тус тус үйлдвэрлэсэн.

Малын гаралтай гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт 2017 онд 517.9 сая ам.долларт хүрсэн нь экспортын орлогын 8.4 хувийг бүрдүүлж байгаа ба энэ нь өмнөх оноос 90.5 сая ам.доллар буюу 21.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Мал аж ахуйн салбарт нийт ажиллах хүчний 30.0 хувь ажиллаж, манай улсын нийт өрхийн 25.9 хувь нь малтай байна. Жилийн дөрвөн улирлын туршид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа малчин өрх 169.7 мянга, малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх 59.2 мянга байна. Малчин өрхийн тоо 2017 онд өмнөх оноос 9.0 мянгаар нэмэгдсэн ч малчдын тоо 7.8 мянгаар буурсан үзүүлэлттэй байна.

Малчин өрхийн болон эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоо жилээс жилд буурах хандлагатай байгаа ч малын тоо 66.2 сая болж, өмнөх оноос 7.6 хувиар нэмэгдэн, малын тоо 5 төрөл бүрт өслөө. 2018 онд 18.0 сая төл шинээр бойжуулж, одоогийн байдлаар улсын хэмжээнд 80.0 гаруй сая мал намаржиж байна.

Малын тоо өсч байгаа нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэх үндсэн нөхцөл болж байгаа ч нөгөө талдаа байгаль экологид үзүүлэх сөрөг нөлөөлөл их байна.

Мал аж ахуйн салбарт малын тооны өсөлтөөс гадна малын харьцаа, сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарч байна. 1992 оноос өмнө мал тооллогын 66 жилийн дүнгээс харахад мал сүрэгт дунджаар бод мал 21.7 хувь, бог мал 78.3 хувийг эзэлдэг байсан бол өнөөгийн байдлаар бод мал 13.2 хувь, бог мал 86.8 хувийг эзэлж байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 90.8 хувийг бог мал, 9.2 хувийг бод мал эзэлж байна. Малын хэрэглээний зарлага 2017 онд өмнөх оноос 1.4 сая толгой буюу 11.1 хувиар өсч, нийт малын 22.9 хувь буюу 14.1 сая толгой малыг хүнсний хэрэглээнд ашигласан.

Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2018 онд үхэр, адууны 60.0 мянган тонн мах экспортлох, хонь, ямааны махыг квотгүйгээр экспортлохоор шийдвэрлэсэн.

Энэ намар, өвлийн улиралд 15.1 сая орчим малыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар тооцож, хэрэглэх малаас нийт 463.0 мянган тонн мах бэлтгэх боломжтой гэсэн тооцоололтой байна. 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар хэрэглээнд 6.0 сая малыг нийлүүлж, 208.0 мянга орчим тонн мах бэлтгээд байна.

Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2017 онд өмнөх оноос 3.3 дахин, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 7 дахин нэмэгдсэн бол 2018 оны 9 дүгээр сарын байдлаарх гаалийн мэдээгээр 31.0 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.9 мянган тонноор нэмэгдсэн байна. Харин дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний экспорт 11.0 мянган тонн болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.8 дахин нэмэгджээ.

2018 оны 9 дүгээр сарын гүйцэтгэлээр БНСВУ-ын чөлөөт бүсэд 0.8 мянган тонн үхрийн мах, БНХАУ, ОХУ, Казакстан, Япон улсад нийт 16.7 мянган тонн адууны мах, Иран улсад 2.1 мянган тонн хонь, ямааны мах, нийт 19.6 мянган тонн мах, 11.0 мянган тонн дулааны аргаар боловсруулсан мах, 0.8 мянган тонн малын дайврыг тус тус экспортлож, 76.1 сая ам.долларын борлуулалт хийгээд байна.

Хоёр. Мал аж ахуйн салбарын тогтвортой өсөлтийг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газар мал аж ахуйн салбарт гарсан ололт, амжилтуудыг бататган бэхжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрх зүйн орчинг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх, дотоод нөөц бололцоогоор эдийн засгийн өсөлт бий болгох, хөрөнгө оруулалт, экспортыг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Мал сүрэг хэдийгээр өсч байгаа ч бэлчээрийн даац хэтэрсэн, малын төрөл хоорондын харьцаа алдагдсан, малын чанар муудсан, малаас хүнд дамжин халдварладаг зарим өвчний тархварын байдал өргөжин хүн, малын өвчлөл нэмэгдэх хандлагатай болсон, малын гоц халдварт өвчин шинээр болон дахин сэргэж байгаатай уялдан мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нөхцөл хязгаарлагдмал байна.

Иймд мал аж ахуйн салбарын хөгжил дэх төрийн зохицуулалт, дэмжлэгийн чиглэл, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үүрэг, хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд Улсын Их Хурлаас баталсан Малын генетик нөөцийн тухай хууль болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна.

Эдгээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Улсын Их Хурлын 1, Засгийн газрын 6 тогтоолыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Мөн

шинээр хэрэгжиж эхэлсэн хоёр хуулийн бусад хууль тогтоомжид үүсэх давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор нэр бүхий 5 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Мал аж ахуйн салбарт эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхэд “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т хэрэгжүүлэхээр заасан “Монгол мал”, “Малын эрүүл мэнд”, “Ноолуур” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, “Монгол малчин”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг тус тус батлан хэрэгжүүлэх болно. “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 21 нэр, төрлийн вакцин, 7 нэр, төрлийн өвчний оношийг илрүүлэхэд шаардагдах 23 төрлийн оношлуурыг дотооддоо үйлдвэрлэн хэрэглэх юм.

Малын генетик нөөцийн тухай хууль болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус салбарын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн зарим бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орууллаа. Тухайлбал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын нэрийг өөрчилж Мал эмнэлгийн ерөнхий газрыг шинэчлэн байгуулсан ба малын үржлийн албаны бүтцийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бүтцэд шилжүүлэн малын үржил, бүртгэлийн асуудал хариуцан ажиллуулахаар боллоо.

Мөн аймаг, нийслэлд Хүнс, хөдөө аж ахуйн болон Мал эмнэлгийн газар, сум, мал бүхий дүүрэгт хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн тасаг ажиллуулахаар бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж байна.

Малын гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэх, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлдэг байх чадавхийг сайжруулах зорилгоор мал эмнэлгийн байгууллагуудыг нэгдсэн нэг удирдлага, зохион байгуулалтад оруулахаар шийдвэрлэсэн.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори болон Биокомбинат төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяанд ажиллуулж эхлээд байна. Мөн Мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяанд ажиллах болно.

Энэхүү өөрчлөлтийг хийснээр мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг хязгаарлах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор, шуурхай, босоо тогтолцоогоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Ингэснээр малын халдварт өвчингүй тайван байдлыг дотоод, гадаад зах зээлд баталгаажуулж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортыг нэмэгдүүлэн, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах юм.

Түүнчлэн Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төвийн аж ахуйн тооцоотой ажиллах зарчмыг өөрчилж, уг төв болон Малын удмын сангийн үндэсний төвийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяанд ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Монгол малын генетик нөөцийг хадгалж хамгаалах, биотехнологийн зарим ололтыг мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, малын үржил, селекцийн ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Малын удмын

сангийн үндэсний төвийн цогцолборыг Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт шинээр байгуулж, ашиглалтад орууллаа.

Тус төвийн генийн санд үндэсний үүлдэр, омгийн болон өндөр ашиг шимт малын 75.5 мянга орчим тун гүн хөлдөөсөн үрийг хадгалж байна. Энэ цогцолборын цаашдын ашиглалт, үр өгөөжийг өндөр технологийн түвшинд хөгжүүлэх, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, молекул генетикийн түвшинд судалгаа шинжилгээг явуулахад чиглүүлж, мал аж ахуйн салбарын суурь судалгааны хөгжлийн түшиц болгон ажиллуулах болно.

Малын тоо, сүргийн бүтцийг зохистой хэмжээнд байлгах, төлөв байдлыг нь үнэлэх, малын нөхөн үйлдвэрлэлийг бүс нутгийн онцлог, шинжлэх ухааны үндэслэлтэй, эдийн засгийн зорилго, чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх, тооноос чанарт шилжих, малын үржүүлэг, тэжээллэг, арчилгаа, маллагааны технологид хяналт тавих, түүний үр дүнг бүх шатанд үнэлж дүгнэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ:

- 2018 онд малын тэжээл тариалалтад зориулж 1.0 тэрбум төгрөг, зөгий үржүүлэгч аж ахуйн нэгжүүдэд 35.0 сая, сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгчдэд 509.0 сая, малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ эрхлэгчдэд 180.0 сая, нийт 1.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох ажлыг Мал хамгаалах сангаар дамжуулан зохион байгууллаа.
- Махны чиглэлийн өндөр ашиг шимт хонины үржлийн аж ахуй байгуулах зорилгоор төслийн сонгон шалгаруулалт явуулж, махны чиглэлийн үржлийн 621 эм хонь, 36 хуц, нийт 657 хонийг Франц Улсаас импортлон, тэдгээрийг нутагшуулж байна.
- Шинэ хөдөө төслийн хүрээнд махны чиглэлийн герефорд үүлдрийн үржлийн өсвөр бух 25 толгой, Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух 100 толгой, Баяд үүлдрийн үржлийн өсвөр хуц 160 толгой, Дархад үүлдрийн үржлийн өсвөр хуц 200 толгой, Эрчмийн хар омгийн үржлийн өсвөр ухна 180 толгой, герефорд үүлдрийн бухны гүн хөлдөөсөн 6.0 мянган тун үр, зохиомол хээлтүүлгийн 4 иж бүрдэл тоног төхөөрөмжийг 494.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авч Булган аймгийн иргэн, аж ахуйн нэгжид олгосон.
- Засгийн газраас зарласан Мах, сүүний анхдугаар аяныг эрчимжүүлэх зорилгоор мах, сүүний чиглэлийн үхэр үржүүлж буй 52 аж ахуйн нэгжид 800.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Мөн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд мал аж ахуйн үйлдвэрлэлд эрчимжүүлэлт хийх чиглэлээр ихээхэн санал санаачилгатай ажиллаж байна. Тухайлбал, "Газар агро" ХХК махны чиглэлийн герефорд үүлдрийн 150 үхрийг ОХУ-аас, "Сэлэнгэ тариа" ХХК лимузэн үүлдрийн 60 толгой үхрийг Герман Улсаас импортлон өсгөн үржүүлж, энэ төрлийн аж ахуй эрхэлж байгаа аж ахуйнуудыг сайн чанарын цэвэр үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчээр хангахаар ажиллаж байна.

Цаашид хүн ам олноор төвлөрсөн нийслэлийн, аймгийн төвийн орчмын болон газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн кластерын загвар аж ахуй, цогцолборыг бий болгох, энэ арга хэмжээнд олон улсын хөрөнгө оруулагчид, мэргэжлийн холбоод, судлаачид, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулахаар төлөвлөж байна.

Завхан, Хөвсгөл, Ховд аймгаас стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой үржлийн 482 сарлагийг 375.0 сая төгрөгөөр худалдан авч, Говь-Алтай аймгийн зарим сумдад нийлүүлснээр сарлаг үхрийн чанарыг сайжруулах,

тоо толгойг нь өсгөх зорилтыг хэрэгжүүлж байна. Цаашид энэ арга хэмжээг Архангай, Хөвсгөл зэрэг аймгуудад хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр сарлагийн ноолуур, хөөврөн бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд гарах, цар хүрээгээ тэлэх нөхцөл суурийг бүрдүүлэх юм.

Түүнчлэн мал, амьтны тоог үнэн зөв тогтоох, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөц, хангамж, чиг хандлагыг тодорхойлох, тэдгээрийн чанар, аюулгүй байдалд бүртгэлээр дамжуулан хяналт хийх, үйлдвэрлэл, экспортын гарал үүслийг баталгаажуулах системийг хөгжүүлэх, малын хулгайн гэмт хэргээс сэргийлэх, шилжилт хөдөлгөөнд хяналт тавихад малын бүртгэл, мэдээллийн үндэсний нэгдсэн сан чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Тус сангийн бүртгэлд одоогийн байдлаар нийт малчин өрх, малчдын мэдээлэл бүрэн орсон ба малын бүртгэлийн ажлыг эхлүүлээд байна.

Гурав. Малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Улсын хэмжээнд 2017 онд давхардсан тоогоор 540 суманд 1140 удаагийн малын халдварт өвчний гаралт, өвчлөл бүртгэгдэж, нийт 20 нэрийн халдварт өвчин гарсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрыг 2018 оны 6 дугаар сард шинэчлэн байгуулах үед шүлхий өвчний гаралт 13 аймаг, нийслэлийн 45 сум, дүүрэгт бүртгэгдэж, хорио цээрийн дэглэм нэг аймгийн 5 суманд хэрэгжин вакцины нөөц дуусаад байсан.

Мал эмнэлгийн ерөнхий газар байгуулагдсанаас хойш өвчний гаралтыг хяналтад авч шуурхай ажилласнаар 2018 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн дэглэм бүрэн цуцлагдсан, шинээр бүртгэгдсэн тохиолдолгүй, гоц халдварт шүлхий өвчнөөр тайван статусыг хадгалж байна.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх зорилгоор шүлхийн вакцинжуулалтад 2017 онд 20 аймгийн 188 сумын 60.9 мянган малчин өрхийн 14.2 сая толгой малыг хамруулсан бол 2018 онд давхардсан тоогоор 20 аймгийн 160 сумын 10.3 сая толгой малыг дархлаажуулалтад хамруулсан.

Мөн зүүн болон төвийн бүсийн эрсдэл бүхий аймгуудад 2.5 сая толгой малыг вакцин дархлаажуулалтад хамруулах ажлыг гүйцэтгэж, вакцины дараах дархлаа шалгах ажлыг 11 дүгээр сард багтаан хийхээр ажиллаж байна.

Өвчний эрсдэл бүхий баруун бүсийн аймгуудын мал сүргийг дархлаажуулалтад хамруулахаар 7.0 сая тун вакциныг 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч, 5 аймгийн 65 сумын 5.8 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулахаар вакциныг хүргүүлэн, тарилгын ажлыг эхлүүлээд байна.

Малаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд бруцеллёзын вакцинжуулалтад 2016 онд 13.3 сая, 2017 онд 22.0 сая толгой малыг хамруулсан бол 2018 онд 13.4 сая толгой төл хамруулахаас 11.6 сая төлийг хамруулж, гүйцэтгэл 86.6 хувьтай байна.

Мал, амьтны архаг халдварт зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцинжуулалтад нийт 33.5 сая толгой мал хамруулахаас 2018 оны 9

дүгээр сарын байдлаар 28.7 сая толгой малыг хамруулж, гүйцэтгэл 85.7 хувьтай байна.

Малын шимэгчтэх өвчнөөс сэргийлэх ажлыг орон даяар хэрэгжүүлж нийт мал сүргийн 30 хувийг угаалгад хамруулахаар төлөвлөснөөс 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 96.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ чиглэлийн ажил үйлчилгээнд ашиглах мал угаалгын зөөврийн 220 ширхэг тоног төхөөрөмжийг аймгуудад нийлүүлсэн ба ариутгал халдваргүйжилтийн тусгай зориулалтын авто машинаар 8 аймагт парк шинэчлэл хийж, 4 бүсэд нян судлалын иж бүрэн лаборатори байгуулах боломжийг бүрдүүлэв.

Дөрөв. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Энэ жилийн өвөл, хаврын бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтээс үзвэл нийт нутгийн 60 гаруй хувьд малын өвөлжилт, хаваржилт хэвийн байх, харин нутгийн 40 шахам хувьд бэлчээрийн хүрэлцээ муу байна.

Бэлчээрийн ургамлын ургалт 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт нутгийн 80 орчим хувьд хэвийн, 20 гаруй хувьд дунд, Баянхонгор аймгийн зарим сумдад муу үнэлгээтэй байна. Бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбоотойгоор Ховд, Баянхонгорын ихэнх, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн зарим сумдын нутгаар малын өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч болзошгүй байна.

Иймд малын өвөлжилт, хаваржилттай холбогдсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд зориулж 21 аймагт 900.0 сая төгрөгийн хөрөнгө олгон, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар улсын тусгай хэрэгцээний аймаг, дундын отрын бэлчээрийн талбайн хэмжээ 783.0 мянган га буюу нийт талбайн 1 хувь, аймаг, сумын отрын нөөц бэлчээрийн талбай 5,439.0 мянган га буюу нийт талбайн ердөө 4 хувийг эзэлж байна. Одоогийн байдлаар отрын 9 бүс нутагт жилд ойролцоогоор 500-700 мянган толгой малыг өвөлжүүлэх боломж байна.

Мөн өвөлжилт, хаваржилтийн бэлтгэлийг эрчимжүүлэх зорилгоор “Хадлан тэжээл-2018” уралдааныг орон даяар зарлаж, аймаг, сумын аюулгүйн нөөцөд 25.9 мянган тонн өвс, 14.7 мянган тонн тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулж байна.

Бэлчээрийн ургамлын ургацын байдлаас харахад энэ жил 1.0 сая тонноос дээш хадлан бэлтгэх боломжтой юм. Одоогийн байдлаар малчдын түвшинд хадлан тэжээлийн бэлтгэл 58.3 хувьтай байна.

Хадлан бэлтгэлд зориулж ОХУ-аас техникийн зээлийн хүрээнд хаман боогч 40 ширхэг, бага оврын трактор, хадуур тармуур тус бүр 20 ширхэг орж ирснийг 30 хувийн урьдчилгаатай, 5 жилийн хугацаатай лизингээр олгох ажлыг зохион байгуулсан. Мөн Хөгжлийн банкны “Ди Би Эм Лизинг” ХХК-тай хамтран өвс хаман боогч 29 ширхэг, өвс плёнкоор боогч 5 ширхэг, хадуур, тармуур нийт 26 ширхэг, тэжээл хураагч чиргүүлийн комбайн 8 ширхэгийг 10-30 хувийн урьдчилгаатай, жилийн 4.0-5.6 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар аж ахуйн нэгжүүдэд лизингээр олгосон.

Уурагт таримал тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2017 онд 600 га, 2018 онд 1000 га-д царгас тариалсан ба уурагт таримал тэжээл тариалалтыг жил бүр 500-1000 га-гаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах болно.

Эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах зорилгоор улсын хэмжээнд ажиллаж байгаа болон ажиллахгүй байгаа тэжээлийн үйлдвэрүүдийн судалгааг нэгтгэн тэжээлийн үйлдвэр байгуулах талаар судалгааны ажлыг зохион байгуулж байна.

2017 онд нийт нутгаар хуурайшилт ихтэй, өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх боломж хомс байсантай холбогдуулан малын тэжээл, өвсний нөөц бүрдүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодод үйлдвэрлэсэн өвс, хадлан, малын тэжээл, хивэг экспортлохыг түр хугацаагаар хязгаарлаж, үр дүнд нь 25.0 мянган тонн тэжээл дотоод зах зээлд нийлүүлэгдэж, дотоодын өвс, малын тэжээл, хивгээр аймгийн аюулгүйн нөөцийн 89.8 хувь, сумын аюулгүйн нөөцийн 58.6 хувь, малчдын түвшинд бэлтгэх өвс, тэжээлийн 70.1 хувийг тус тус бүрдүүллээ.

Дутагдаж буй өвс, тэжээлийг хангахын тулд өвс, тэжээл дотооддоо үйлдвэрлэх, мөн импортлох замаар малчид, фермерүүдэд нийлүүлж, аж ахуйн нэгжүүдэд 40 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон. Уг ажлын хүрээнд төрөл бүрийн малын тэжээл нийт 50.0 мянган орчим тонныг импортолж 21 аймгийн бүх сумын малчид, фермерүүдэд борлуулсан нь өвлийг өнтэй давахад чухал нөлөө үзүүлсэн.

Тав. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын өнөөгийн байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Монгол орны бэлчээрийн талбайн хэмжээ 1961 онтой харьцуулахад 2017 оны байдлаар 27.9 сая га буюу 19.9 хувиар буурч, 112.1 сая га боллоо. Нийт бэлчээрийн талбайн тавны нэг нь уул уурхай, хот суурин зэрэг суурьшлын болон бусад салбарт шилжсэн байна. Ингэснээр 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1961 онд 32 байсан бол 2017 онд 99 болж, бэлчээрт үзүүлэх ачаалал 3.1 дахин нэмэгдсэн байна.

Ус, цаг уурын улсын сүлжээний бэлчээрийн төлөв байдлын мониторингийн 1516 зогсоол цэг дээрээс хийсэн 2016 оны судалгаа, дүн шинжилгээгээр Монгол орны нийт бэлчээрийн 57 хувь унаган төлөв байдлаас өөрчлөгдөж доройтсоноос 13.0 хувь бага зэрэг, 21.1 хувь дунд зэрэг, 12.8 хувь хүчтэй, 10.3 хувь бүрмөсөн цөлжих эрсдэлд орсон байна.

Доройтсон бэлчээрийн хувь хэмжээ үндэсний хэмжээнд 2014 оны суурь мэдээллээр 65.0 хувь байсан бол 2016 оны байдлаар 57.0 хувь болж буурсан хэдий ч хүчтэй доройтож, цөлжих аюулд хүрсэн бэлчээр нутгийн хэмжээ 3.3 хувиар нэмэгджээ.

Сүүлийн 5 жилд хадлан бэлчээрийн талбай 0.1-0.6 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 8.0-36.1 сая толгойгоор өссөн байна. Үүнтэй холбогдон 100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1.1-1.5 дахин нэмэгджээ. Ялангуяа төвлөрсөн хот, суурин газар, мал ихтэй бүс нутаг, аймагт бэлчээрийн даац 1.8 -7.5 дахин хэтрээд байна.

Ийнхүү малын тоо өсч бэлчээрийн газрын талбай хумигдаж байгаа нь малыг тэжээлээр хангах эх үндэс болох бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтыг

сайжруулах, нийт нутаг дэвсгэрийн 73.3 хувийг эзэлдэг бэлчээрийн газрын харилцааны зарим эрх зүйд нарийвчилсан зохицуулалт хийж, Бэлчээрийн тухай бие даасан хуулийг бий болгох, бэлчээрийн төлбөрийг бүс нутгийн онцлогтой уялдуулан тогтоох, бэлчээрт хариуцлагын механизм бүрдүүлэх асуудлыг хэлэлцэх цаг нэгэнт болжээ.

Ашиглагдахгүй байгаа нөөц бэлчээрийг ашиглах, гантай байсан аймгуудад усан хангамжийг сайжруулах, ажлын хүрээнд 2018 онд 17 аймаг, 2 отрын бүс нутагт 4.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 174 инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг зохион байгуулж байна.

2017 оны статистик мэдээгээр манай улс хөдөөгийн хүн ам, малыг усаар хангах зориулалт бүхий 43.8 мянган худагтай, үүний 28.3 хувь буюу 13.6 мянга нь инженерийн хийцтэй, 71.7 хувь буюу 30.2 мянга нь гар худаг байна. Худгийн 70 гаруй хувь нь хүчин чадал багатай энгийн уурхайн худаг байгаа нь нэг цэг дээрх малын бөөгнөрөл хэт их болж, цэгэн цөлжилт, бэлчээрийн талхагдал үүсч байгааг судалгаагаар тогтоосон.

Улсын төсвийн хөрөнгөөр инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг жил бүр зохион байгуулж, бэлчээрийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр ажилладаг. Энэ ажлын хүрээнд 2018 онд 17 аймаг, 2 отрын бүс нутагт 4.2 тэрбум төгрөгөөр нийт 174 инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 487.2 мянган мал сүрэг, 261.0 мянган га бэлчээр, 870 гаруй малчин өрхийн усан хангамжийг шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.

Ган, зуд, цаг агаарын бэрхшээл тохиолдсон үед нийт малынхаа 10 хувь буюу 5-6 сая малыг отрын бүс нутагт өвөлжүүлэх, хаваржуулах боломжтой аймаг дундын отрын нөөц нутаг бий болгох зорилт тавин ажиллаж байна.

Бэлчээрийг сайжруулах, багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулж, 2018 онд 16 аймгийн 750.0 мянган га талбайг эргэлтэд орууллаа.

Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр олон улсын байгууллагын дэмжлэг бүхий тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд орон нутагт Бэлчээр ашиглагчдын хэсгийн зохион байгуулалтад орж, сумдын Засаг даргатай бэлчээр ашиглах гэрээ байгуулан бэлчээрийг хуваарьтай ашиглах, доройтсон бэлчээрийг сэлгэн өнжөөх, сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр туршилт, сайн загварыг гарган ажиллаж байна.

Мөн Мерси кор олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 11 аймгийн 45 суманд мал аж ахуйн эрсдэлийг бууруулах, бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор бэлчээрийн менежментийн дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Доройтсон бэлчээрийг сэлгэн өнжөөж, нөхөн сэргээх арга хэмжээг 5 аймгийн 30 мянган га-д зохион байгууллаа. Улсын тусгай хэрэгцээний отрын бүс шинээр байгуулах судалгааг явуулснаар 87.0 мянган га бэлчээрийг улсын тусгай хэрэгцээнд авах боломжтой болохыг судалж тогтоогоод байна.

Хөдөөгийн хүн ам, мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд улсын төсвөөс 107, гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр 35, орон нутгийн төсвөөс 213 инженерийн хийцтэй худаг, малчдын санаачлагаар 319 гар худаг, нийт 674 худаг шинээр гаргасан.

Төрөөс мал аж ахуйн талаар баримталж байгаа урт, дунд хугацааны бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлого нэмэгдэж, уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх чадавхи бэхжин, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанартай, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, экспортын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Монгол Улсын мал аж ахуйн салбарыг дэлхий нийтэд таниулах замаар зах зээлээ нээх, мал аж ахуйн хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судалж, нэвтрүүлэх зорилгоор энэ оны 6 дугаар сард Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн олон талт түншүүдийн 8 дугаар уулзалтыг Монгол Улсдаа амжилттай зохион байгууллаа.

Нүүдлийн мал аж ахуйн соёл иргэншилд томоохон байр суурь эзэлдэг манай орны хувьд Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөртэй хамтран ажиллах нь энэхүү соёл иргэншлээ хадгалан хөгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, бэлчээрийг зохистой ашиглах, мал аж ахуйн үйлдвэрлэлд шилдэг технологи, инноваци нэвтрүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Мал аж ахуйн үйлдвэрлэлд дэлхийн дулаарлын нөлөөллийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох технологи боловсруулах, нутагшуулах "ухаалаг" системийг хөгжүүлснээр бид үндэсний хэмжээний болон бусад бүс нутгийн хүн амын хүнсний хангамжид хувь нэмэр оруулах, эдийн засгийн интеграцид нэгдэх боломжийг улам бүр нэмэгдүүлэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР